



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 1175

Хархорин сум

Г Цэрэг татлагын ажил зохион  
байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Монгол улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэрэг татлагын ажлыг 2024 оны 10 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсугай.

2. Цэрэг татлагын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, ажил үүргийн хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Цэргийн 18-25 насны залуучуудыг цэрэг татлагад бүрэн хамруулж, бэлтгэл ажил хангахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Цэрэг татлагаар шинжилгээ авах бэлтгэл ажлыг зохион байгуулж, тоног төхөөрөмж, ажиллах мэргэжлийн эмч, сувилагч томилгоожуулан ажиллахыг Нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Үүрийнтуяа)-д үүрэг болгосугай.


5. Цэрэг татлагын ажил зохион байгуулахад шаардагдах санхүүжилтийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Лхагвадулам), гүйцэтгэлээр тайлагнахыг нягтан бодогч (О.Гангаацэрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Г.ОДГЭРЭЛ

401100343

Хархорин сумын Засаг даргын 2024 оны  
09 дүгээр сарын 18-ны өдрийн 11:15 дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт



## ЦЭРЭГ ТАТЛАГЫН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Х.Лхагвадулам (Засаг даргын Тамгын газрын дарга)
Орлогч:	Н.Нямдаваа (Хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн)
Гишүүдэд:	А.Цэрэнчимэд (Нийгмийн бодлогын мэргэжилтэн) Т.Алтангэрэл (1 дүгээр багийн Засаг дарга) Р.Сүхбат (2 дугаар багийн Засаг дарга) Д.Батчулуун (3 дугаар багийн Засаг дарга) Г.Отгонбаяр (4 дүгээр багийн Засаг дарга) Б.Ганхуяг (5 дугаар багийн Засаг дарга) Л.Төгөлдөр (6 дугаар багийн Засаг дарга) О.Батсүх (7 дугаар багийн Засаг дарга) П.Нэндором (8 дугаар багийн Засаг дарга) Б.Пүрэвсүрэн (1 дүгээр багийн Зохион байгуулагч) Б.Сарангэрэл (2 дугаар багийн Зохион байгуулагч) Д.Хишигсүрэн (3 дугаар багийн Зохион байгуулагч) Н.Отгонбаяр (Нярав) Б.Мөнхзул (Угтах үйлчилгээний ажилтан) З.Энхтүвшин (Насан туршийн боловсролын арга зүйч)

Нарийн бичгийн дарга: Ж.Солонго (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Хархорин сумын Засаг даргын 2024 оны  
дүгээр сарын 18-ны өдрийн 11 дугаар  
захирамжийн 2 дугаар хавсралт

АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

Албан тушаал	Нэр	Гүйцэтгэх ажил
Тамгын газрын дарга	Х.Лхагвадулам	<ol style="list-style-type: none"><li>Зарлан дуудах хуудасны гарын үсэг зуруулж баталгаажуулсан хувийг хүлээн авч багийн Засаг дарга нартай тооцоо хийх;</li><li>Цэргийн үүрэгтний үнэмлэхний тооцоо хийж, дутагдалтай бол захиалж авах ажлыг зохион байгуулах;</li><li>Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэдийн мөнгөн төлбөр төлсөн тухай баримт бичгийг бүрдүүлэх, төлбөрөө төлөөгүй болон шинээр төлбөр тогтоолгох иргэдийн нэrsийг он оноор нь гаргаж зарлан дуудах хуудас өгч бэлэн байлгах;</li><li>Цэргийн дүйцүүлэх албыг биеэр хааж байгаа иргэдийг холбогдох баримт бичгийн хамт бэлэн байлгах, хийсэн ажлын үр дүнг хүн нэг бүрээр тооцсон тооцооны хуудас, гурвалсан гэрээг бүрдүүлэх;</li><li>Цэрэг татлага явуулах хугацаанд нийгмийн хэв журмыг Цагдаагийн байгууллагатай хамтран хангуулах;</li></ol>
Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн	Н.Нямдаваа	<ol style="list-style-type: none"><li>Цэрэгт татагдагчдын нэrsийн жагсаалтыг маягтын дагуу гаргаж, бэлэн болгох;</li><li>Сумын цэрэг татлагын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг хуралдуулж хуульд заасан шалтгаанаар чөлөөлүүлэхийг хүссэн иргэдийн асуудлыг шийдвэрлэх;</li></ol>
Нийгмийн бодлогын мэргэжилтэн, Насан туршийн боловсролын арга зүйч	Ж.Солонго Ц.Цэрэнчимэд З.Энхтувшин	<ol style="list-style-type: none"><li>Цэргийн насны залуучуудыг эрүүлжүүлсэн тайланг овог, нэртэй нь үнэн зөв бодитой гаргах, өвчлөлийг өмнөх онтой нь харьцуулсан судалгааг өвчлөл тус бүр дээр өссөн, буурсан үзүүлэлттэйгээр нарийвчлан гаргах;</li><li>Цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэг явуулах байрыг зөвлөмжийн дагуу бэлтгэх;</li><li>Зарлан дуудах хуудас олгох;</li><li>Цэрэг татлагын зарыг бүх хэлбэрээр хургэх;</li></ol>
Нярав	Н.Отгонбаяр	<ol style="list-style-type: none"><li>Бичиг хэргээр бүрэн хангах</li><li>Цэрэг татлагын байрны бэлэн байдлыг хангах</li></ol>

<p>Багийн Засаг дарга,  Зохион байгуулагч нар</p>		<p>1.2024 оны шинэчилсэн тоо бүртгэлийн материал судалгааг үндэслэн 18-25 насны эрчүүдийн судалгааг гаргаж, цэрэг татлагын байранд ирэх оюутан залуусын судалгааг нарийвчлан гаргах;</p> <p>2.Иргэний үнэмлэхгүй залуусыг үнэмлэхжүүлэх ажлыг Улсын бүртгэгчтэй хамtran зохион байгуулах;</p> <p>3.Зарлан дуудах хуудсыг цэрэгт татагдагчдад гардуулах, цэрэг татлагын байранд ирүүлэх;</p> <p>4.Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр оруулан хаах иргэдийн нэрсийг гаргаж, аймгийн Цэргийн штабт явуулсан нэртэй тулгаж, бэлэн болгох;</p> <p>5.Цэрэгт татагчдын анкетийг үнэн зөв, дэлгэрэнгүй бичиж бэлдэх;</p>
---	--	--

---оОо---